

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ  
НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**  
/Хүлээгдэж буй гүйцэтгэлээр/

2020 оны 06 дугаар сарын 12

Багануур дүүрэг

№	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Шалгуур үзүүлэлт	2020 онд хүрэх түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Үнэлгээний хувь
1	2	3	4	5	6	7	8
<b>НЭГ. ЭДИЙН ЗАСАГ, ЭРХ ЗҮЙН ШИНЭ ОРЧИН БҮРДСЭН ХОТ</b>							
<b>Эдийн засаг, төсөв санхүүгийн чиглэлээр:</b>							
1	1.10. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	1.10.1. Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн ажлыг эхлүүлнэ.	БҮТП ОНӨТҮГ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	93%	
<p><b>Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.57 - Хөнгөн үйлдвэрийн парк байгуулж, салбарын үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг дэмжин, кластерыг бүртгэлжүүлэн бодлогоор дэмжинэ, 2.73 - Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ, 3.2.37 - Нээлттэй лабораторид суурилсан био, нанотехнологийг хөгжүүлж, оюуны багтаамж өндөртэй, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлнэ, 4.1.6 - Хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлнэ зэрэг зорилтуудын дагуу паркийн үндсэн үйл ажиллагааг чиглүүлэн ажиллаж байна.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- 2016 онд Парк байгуулах 414,0 га газар 6 байршилд эзэмших НЗД-ын захирамж, паркийн үйл ажиллагаа эрхлэх тухай ЗГ-ын тогтоолоор Тусгай зөвшөөрөл</li> <li>- 2017 онд Паркийн хөгжлийн дунд болон урт хугацааны Стратеги төлөвлөгөө баталсан.</li> <li>- 2017-2018 онд Паркийн хөгжлийн эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдийг боловсруулан батлуулсан.</li> <li>- 2020 оны эхний хагас жилийн байдлаар Паркийн хөгжлийн эхний дунд хугацааны стратеги төлөвлөгөө, CROSS SWOT шинжилгээнд дүгнэлт хийж, Паркийн хөгжлийн II дунд хугацааны стратеги төлөвлөгөөг гарган, ЗГ-ын хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаартай тушаалын 2 дугаар хавсралтын дагуу 1 дүгээр бүлгийн төслийг боловсруулан удирлагаар хянуулсан.</li> </ul>							

- 2018-2021 онд “Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөтөлбөр”-т болон 2019 оны ЗГ-ын баталсан “Шинэ бүтээн байгуулалтын хөтөлбөр”-т БҮТП-ийг 2025 онд иж бүрнээр байгуулах заалтууд тус тус батлагдсан.

- 2017-2019 онд Паркийн нийт эзэмшил газарт Байгаль орчны болон Газрын чанарын улсын хянан баталгаа, Техник технологийн нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнүүд мэргэжлийн байгууллагуудаас хийж баталгаажуулсан.

**2017 онд БХБЯ-д 789,0 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлүүлэн тус яамны захиалгаар “Мон-энержи Консалт” ХХК нь гүйцэтгэгчээр ажиллаж:**

1. 2018-2019 онд Паркийн Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт боловсруулж, НИТХ-аар батлуулж, БХБЯ-ны Экспертиз зөвлөл хянан баталгаажуулсан.
2. 2018-2019 онд Паркийн инженерийн дэд бүтцийн иж бүрэн зураг төсөл боловсруулж дуусах шатанд ажилласан.
3. Хөрөнгө оруулалтын бүхий л салбарт БҮТП-д хөрөнгө оруулалт татах, төлөвлөгдсөн үйлдвэрүүдийн төслүүдийг танилцуулах, БААН болон гадаадын хуулийн этгээдүүдээс ирүүлж байгаа төслүүдэд судалгаа шинжилгээ хийж холбогдох дээд шатны байгууллагад танилцуулан дүгнэлт хүргүүлэн ажиллаж байна.

2020 онд дэд бүтцийн бүтээн байгуулалтад Нийслэл болон улсын төсвөөс санхүүжилт тавигдаагүй боловч Паркийн удирдлагын зүгээс хөрөнгө оруулалт татах ажлыг эрчимтэй зохион байгуулан ажиллаж байна.

- Дүүрэг болон Нийслэлийн засаг дарга нарт боломжтой нөхцөлүүдийг танилцуулан үүрэг чиглэл авч, дэс дараатай арга хэмжээ авч ажилласнаар Паркийн цахилгаан эрчим хүчний ерөнхий хангамжийн 7,3 км 110/35/10 кВ-ын ЦДАШ-ыг Багануур дүүрэгт төмөрлөгийн үйлдвэр барих төсөл хэрэгжүүлж байгаа “МЕСЕС” ХХК-тай хамтарсан хөрөнгө оруулалтаар байгуулах гэрээ байгуулан ажиллаж байна. “МЕСЕС” ХХК нь эхний ээлжинд өөрийн хөрөнгөөр дээрхи бүтээн байгуулалтыг хийж паркийн өмчид 100% хүлээлгэн өгөх юм.

Энэхүү төсөл хэрэгжснээр БҮТП-д эхний ээлжинд хүнд үйлдвэрийн чиглэлийн 2 үйлдвэр, “Адуу” брэндийн өргөтгөлийн ажлыг эхлүүлэх боломжтой болох ба мөн 80 гаруй ажлын байр шинээр бий болгохоор зорьж байна.

- 04 дүгээр сард Газрын дарга нь цахилгаан хангамжийн техникийн нөхцөл авах ажлыг эрчимжүүлэн БХБЯ, БХТ, ЭХЯ, Диспетчерийн үндэсний төвтэй уулзалт зохион байгуулан техникийн нөхцөлд тулгамдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн зөвлөсний дагуу Багануур 220/110/35 кв-ын дэд станцийн 110 кв-ын талаас хангуулахаар “Диспетчерийн үндэсний төв” ХХК-аар цахилгаан хангамжийн горим ачааллын тооцоог гүйцэтгүүлэн 2020.05.27-нд хүлээн авсан. Мөн “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Зүүн Өмнөд бүсийн салбарын холбогдох инженер техникийн ажилтнуудтай уулзалт хийж цахилгаан хангамжийн холболтын схем болон хэрэглээ ачаалалын гаргалгааг зөвшилцөв. 2020.06.09 өдөр ЭХЯ-д дээрхи ЦДАШ-ыг байгуулах тухай техникийн нөхцөл цахим хэлбэрээр хүсэж холбогдох материалуудыг оруулав. Мөн хөрөнгө санхүүжилтийн төслийг 2020.06.03 өдрийн А/102 албан бичгээр НЗД-д, мөн өдрийн 100 дугаартай албан бичгээр дүүргийн ЗД-д тус тус уламжилсан.

		<p>4. 2008 онд Үйлдвэр худалдааны яам Багануур дүүрэгт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зориулалтаар, конторын барилгыг 1067 м.кв газрын хамт худалдан авсан. Энэхүү газрыг УУХҮЯ-наас Паркийн эзэмшилд шилжүүлэн авч Паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн барилгыг шинээр байгуулахаар төлөвлөж, зураг төслийн санхүүжилтийг нийслэлийн Засаг даргын 2019 оны А/619 дугаар захирамжаар 35,0 сая төгрөг шийдвэрлүүлэн, гүйцэтгэгч байгууллагаар Нутаг Консалтинг шалгарч, одоогийн байдлаар Паркийн Үйлдвэрийн албан конторын барилгын гадна болон дотор инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулагдаж, дүүргийн хангагч байгууллагуудтай зөвшилцөн магадлалаар хянагдан баталгаажуулан, Зураг төслийн нэгдсэн дүгнэлтийг гаргуулахаар бэлтгэж байна.</p> <p><b>ДҮГНЭЛТ</b> Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны мөрийн хөтөлбөр, Гурван тулгуурт хөгжлийн бодлогын хүрээнд Монгол Улсын 2018-2021 оны Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт, нийслэлийн Засаг даргын болон дүүргийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт тус тус тодорхой тусгал чиглэлээ олсон:</p> <ul style="list-style-type: none"> <li>- БҮТП-ийг байгуулах,</li> <li>- Нүүрс угаах, баяжуулах, гүн боловсруулах замаар стратегийн гол нэрийн түлш шатахуун, нийлэг хийг дотоодод үйлдвэрлэх,</li> <li>- Импортыг орлох барилгын материалын үйлдвэрүүдийг байгуулах,</li> <li>- Томоохон үйлдвэр дагасан ЖДҮ-ийн хөгжлийг дэмжиж, төрөлжсөн кластер бий болгох,</li> <li>- Өвөл зуны хүлэмжийн цогцолбор аж ахуйг байгуулах замаар биотехнологиор ховор болон ашигт эмийн ургамлын тариалалт, түүнээс эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх,</li> <li>- Нанобиотехнологийн шийдлээр малын гаралтай эрүүл мэндийн бүтээгдэхүүн гарган, хүн амыг хангах зэрэг олон төлөвлөлтийг дэс дараатай хэрэгжүүлэх орчин бүрдсэн байна.</li> </ul> <p><b>ЦААШДЫН ЗОРИЛТ</b> Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн дунд болон урт хугацааны Стратеги төлөвлөгөөний хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. 2020-2025 дэд бүтцийн бүтээн байгуулалтыг иж бүрэн гүйцэтгэнэ.</li> <li>2. 2021-2030 онд Паркад хэрэгжүүлэх төсөл, хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.</li> </ol>					
<b>ГУРАВ. БАЯЛАГ БҮТЭЭГЧДЭЭ ДЭМЖСЭН, ҮЙЛДВЭРЛЭЛ ХӨГЖСӨН ХОТ</b>							
2	3.1. Үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд нано технологи, аж үйлдвэрийн цогцолбор байгуулж, томоохон болон жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх замаар эдийн засгийн	<p>3.1.1. "Адуу" брэндийн бүтээгдэхүүнийг экспортод гаргах ажлыг бодлогоор дэмжинэ.</p> <p>Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн бүтцийн үндсэн нэгж байгууллага ШУҮ-ийн Монхимо ХХК нь 20 гаруй жилийн туршилт судалгааны ажлын үр дүнд "Адуу" брэндийн цуврал бүтээгдэхүүнийг зах зээлд гаргаж, хүн амын дунд ихсэж буй "Яс сийрэгжилт" өвчнөөс урьдчилан сэргийлэхэд эрэлт хэрэгцээтэй, гаж нөлөө багатай, био органик бүтээгдэхүүнийг бий болгосноор "Эрүүл Монгол хүн" хөтөлбөр хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.</p>	<p>БҮТП ОНӨТҮГ</p> <p>Монхимо ХХК</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	100%	100%	

	<p>чадавхыг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана.</p>	<p>Үйлдвэрлэлийн мэдээллээс товчхон дурьдвал Малын гаралтай биологийн идэвхит бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хувьд 10 нэр төрлийн 59,3 мянган флакон бүтээгдэхүүн, Ариутгалын бодис, эмийн үйлдвэрлэлийн чиглэлийн 31 нэр төрлийн 959 мянга флакон бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд гарган ажилласан. 2020 оны 01 дугаар сарын 16-ны өдөр “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ, Шинжлэх ухаан, Үйлдвэрлэлийн “Монхимо” ХХК-тай Нэгжийн удирдлагын гэрээг шинэчлэн байгуулсан. Ковид-19 цар тахалтай холбоотой бүтээгдэхүүн экспортлох үйл ажиллагааг түр зогсоож дотооддоо нийлүүлэлт хийж байна.</p>					
		<p>3.1.2. Эрдэм шинжилгээ, шинэ бүтээлийн судалгаа, туршилтыг явуулах, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>БҮТП ОНӨТҮГ</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	<p>100%</p>		
<p>3</p>		<p>Паркийн дэргэд “Эрдэм шинжилгээ судалгааны инкубатор инноваци”-ийн төв байгуулсан. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль болон Засгийн газрын 2017 оны 295, 104 дүгээр тогтоолуудыг үйл ажиллагаандаа удирдлага болгон их сургуулийн эрдэмтэд, судлаач багш нарын шинжлэх ухаанч үйл ажиллагааг үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглүүлэх зорилгоор ФТХ, ЕБСБХ, УХЭШХ, ХААИС, ШАУИС, ШУТИС-тай тус тус санамж бичиг, гэрээ байгуулан, хамтын ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллаж, тодорхой төслүүд дээр судалгааны ажлуудыг эхлүүлээд байна. Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Тухайн ШУТ-ийн байгууллагууд дээр байгаа батлагдсан технологиудаас Паркийн үндсэн чиглэлийн салбаруудад хэрэгжүүлж болох төслүүдийг хамтран судлах</li> <li>2. Паркад хэрэгжих төслүүдэд салбарын эрдэмтэдийн зөвлөмж дүгнэлт гаргуулах</li> <li>3. Уурхайн шорооноос будаг гарган авах</li> <li>4. Цахиурын элсны судалгаа</li> <li>5. Биотехнологийн аргаар ахуйн хог хаягдлаар компост бордоо хийх технологиор дүүргийн иргэд, БААН-ийн дэргэд анхан шатны туршилт судалгааг эхлүүлэх</li> <li>6. Биотехнологийн аргаар ховор эмийн болон ашигт ургамалуудыг тариалах туршилтуудыг эхлүүлэх</li> <li>7. Хүнд үйлдвэрийн салбарт Нүүрс-химийн үйлдвэрлэлээр стратегийн гол нэрийн бүтээгдэхүүн Дизель түлш шатахуун гарган авах төслийг салбарын эрдэмтэд судлаачдын дунд хэлэлцүүлэн дүгнэлт гаргах</li> </ol> <p>Паркийн дэргэд Эрдэм шинжилгээ, судалгааны инкубатор, инновацийн төв /ЭШИИСТ/ байгуулах ажлын хүрээнд 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр ШУТИС, ХААИС, ШАУИС, УХЭШХ-д хамтын ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлж, ЗГ-ын 30 тогтоолын хэрэгжилтийг ханган хамтран дүгнэх ажлыг цахимаар зохион байгуулав. 01 дүгээр сарын 09-ний өдөр МУИС-ийн 10 төлөөлөгч эрдэмтэн багш нарыг хүлээн авч, хамтран ажиллах гэрээ байгуулан төлөвлөгөөг баталж, Багануур ХК-ийн үйл ажиллагаатай танилцуулав. Эхний хагас</p>			<p>100%</p>		

	<p>жилд хийгдэх төлөвлөгөөт үйл ажиллагаанууд корона вирусын цар тахлын улмаас тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон.</p> <p>8. 2019 онд Монгол улсын Үндэсний хөгжлийн газар болон GIZ ЭТИС хөтөлбөр хамтран “Жижиг, дунд бизнесийн инновациудыг дэмжих сан”, “Залуу эрдэмтэд, гарааны бизнесийн инновациудыг дэмжих сан”, “Бүтээлч сэтгэлгээ, медиа болон цахимжуулалтын төрлийн инновациудыг дэмжих сан” байгуулсан бөгөөд эдгээр сангуудын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд Инноваци 2019 төсөл сонгон шалгаруулалтыг зарласан. Паркийн зүгээс Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар компост бордоо хийх үйлдвэр, Багануур цахилгаан механикийн үйлдвэрээс гарах төмрийн хаягдал хэрчдэсээр бэлэг дурсгалын зүйл хийх үйлдвэр, Багануурын нүүрсний уурхайн овоолгын шорооноос будаг гаргах үйлдвэр, Багануурын нүүрсний уурхайн овоолгын шорооны элсээр зүлгүүр хийх үйлдвэрийн инновацийн төслүүдийг боловсруулж амжилттай оролцсон.</p> <p>9. 2020 онд Олон улсын хамтын ажиллагааны КОЙКА байгууллагын төр хувийн хэвшлийн түншлэлийн хөтөлбөрт тусгуулах инновацийн 2 төслийн саналыг боловсруулж 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 22 дугаартай албан бичгээр хүргүүлэв.</p> <p>10. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д жижиг, дунд үйлдвэр, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчныг бүрүүлэх, ажлын байр бий болгох гэсэн заалтын хүрээнд дүүргийн ЖДҮДТ–тэй 2019.03.22-нд хамтран ажиллах Санамж бичиг байгуулсан ба нийт 5 ажил төлөвлөснөөс 2 ажлыг 2020 онд үргэлжлүүлэхээр болсон. Шинэ төрлийн корона вирусын цар тахалтай холбоотойгоор цахимаар дэвшилтэд техник, технологийн мэдээллийн сангийн жагсаалтыг хүргүүлсэн.</p>		
	<b>Дундаж хувь</b>	<b>97,6%</b>	



БИЕЛЭЛТ ХЯНАСАН:  
 БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА

Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:  
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН: *Lasvit*

Б.НОМИНЗУЛ